



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/413


Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн ИТХ-ын 2022 оны 7/02 тогтоол, Нийтийн тээврийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 1/482 албан бичгийг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод нийтийн тээврийн хэрэгслийн цахим картаар үнэ төлбөргүй зорчсон аймгийн харьяа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн олговорт 1,855.5 мянган төгрөг (нэг сая найман зуун тавин таван мянга таван зуун)-ийг зарцуулсугай.

2. Нөхөн олговорт зарцуулах 1,855.5 мянган төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.



Б.ДҮГЭРЖАВ